

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Ажил олгогчийн хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2021-02-05		ЗТ-21/02-015	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтны амь нас, эрүүл мэндийн өмнө ажил олгогчийн хүлээх хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын эрсдэл, ажил олгогчийна алдаатай эрсдэл					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.1%-1%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Тээврийн хэрэгслийн ослоор ажилтанд учирсан хохирол /Шүүхээр үйлдвэрлэлийн осол биш гэж үзсэн/;
2. Даатгуулагчийн ажилтан нь хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэвэл зохих хугацаанд дур мэдэн өөр ажил гүйцэтгэх болон ажлын байраа орхиж явсан, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэснээс үүдсэн болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны горим, журмыг илт, санаатай зөрчсөний улмаас учирсан хохирол;
3. Ажил үүргээ гүйцэтгээгүй үед гарсан хохирол болон ажлын бус цагаар ажилтанд учирсан аливаа хохирол;
4. Ажилтны өөрийн эрүүл мэндээс шалтгаалан гарсан хохирол;
5. Даатгуулагчийн ажилтнаас бусад гуравдагч этгээдэд учирсан эрүүл мэндийн хохирол;
6. Ажилтан нь даатгалд хамрагдахаас өмнө учирсан ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх зорилгоор дахин эмчилгээ хийлгэж эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол;
7. Ердийн болон халдварт өвчний улмаас хэвтэж эмчлүүлсэн болон тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон, рашаан сувилалын амралтын газар сувилуулж, эмчлүүлсэн бол;
8. Ажилтан нь санаатайгаар өөрийн биед гэмтэл учруулсан, амиа хорлосон, амиа хорлохыг завдсан бол;
9. Ажилтан нь эрүүгийн гэмт хэрэг үйлдэж байхдаа болон үйлдэхийг завдсан үед учирсан хохирол;
10. Тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол;
11. Ажилтан нь сэтгэл санааны хямрал, сэтгэцийн эмгэг, эрх зүйн чадамжгүй үе, саа өвчний улмаас болон түр зуурын шокийн байдлаас үүдсэн гэмтэл бэртэл;
12. Даатгуулагч болон түүний ажилтны бүхий л дотоод шаталтийн хөдөлгүүртэй тээврийн, усан, агаарын тээврийн хэрэгслийг жолоодох үед үүсэх аливаа хохирол;
13. Эд хөрөнгөнд учирсан аливаа хохирол;
14. Цалин хөлс, тэтгэвэр, бусад томилолтын зардал;
15. Мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага, туршлага шаардагдах ажилд ур чадвар, ажлын дадлага, туршлагагүй ажилтныг шууд буюу туршилтын хугацаа, дагалдан ажиллуулах хугацаа олгохгүйгээр томилон ажиллуулснаас үүдсэн хохирол;
16. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдал;
17. Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас учирсан хохирол;
18. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн **90** хоног дотор хүлээлгэн өгөөгүй бол;
19. Тэсэлгээ ашиглан хөрс хуулалт хийж буй ил уурхайн болон далд уурхайн ажилтнуудад учирсан хохирол;
20. Асбест /шөрмөсөн чулуу буюу шилэн хөвөн/ ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй байгууллагын ажилтнуудад учирсан хохирол;
21. Хууль тогтоомжид заасан бусад.